



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын
IV байр. Утас: 51-261668 Цахим шуудан: nbfi@frc.mn

Агуулга

Хүснэгтийн жагсаалт.....	3
Зургийн жагсаалт.....	4
Товчилсон нэрсийн жагсаалт	4
Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал.....	5
Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт	7
Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт.....	8
Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт	8
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт	8
“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт	8
Статистик үзүүлэлтүүд	9
Харилцагчид, зээлдэгчид	9
Хувьцаа эзэмшигчид болон ажилчид	9
Тархалт	10
Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	11
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.....	12
Хөрөнгө оруулалт	13
Зээл.....	13
Цахим зээл	16
Ногоон зээл	18
Факторингийн тооцооны авлага.....	20
Үүсмэл санхүүгийн хөрөнгө, бусад санхүүгийн хөрөнгө.....	20
Санхүүгийн бус хөрөнгө	21
Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт	21
Итгэлцлийн үйлчилгээний өглөг.....	23
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр.....	24
Бусад эх үүсвэр	24
ББСБ-аас гаргасан өрийн бичиг.....	25
Төслийн зээлийн санхүүжилт.....	25
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ).....	26
Бусад санхүүгийн өр төлбөр.....	26
Санхүүгийн бус өр төлбөр	26
Өөрийн хөрөнгө	26
Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	27
Өөрийн хөрөнгийн бусад хэсэг	28
Хуримтлагдсан ашиг	28
Ашигт ажиллагаа	29
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	30
Өгөөжийн үзүүлэлтүүд	31
Гадаад валютын арилжааны мэдээ	31
Дүгнэлт	32
Актив, пассивын бүтэц.....	32
Ашигт ажиллагаа	33
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	33

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл	5
Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд (тэрбум төгрөгөөр).....	5
Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа	5
Хүснэгт 4 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл.....	9
Хүснэгт 5 Статистик мэдээлэл (5 жилээр)	9
Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл	10
Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа.....	10
Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт	10
Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт	10
Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд (сая төгрөгөөр).....	11
Хүснэгт 11 Активын интервал (тэрбум төгрөгөөр).....	12
Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр)	12
Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц (сая төгрөгөөр)	13
Хүснэгт 14 Зээлийн бүтэц (тэрбум төгрөгөөр).....	13
Хүснэгт 15 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар (сая төгрөгөөр)	15
Хүснэгт 16 Зээлийн ангилал (тэрбум төгрөгөөр)	16
Хүснэгт 17 Зээлийн ангилал (мянган төгрөгөөр)	16
Хүснэгт 18 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд (мянган төгрөгөөр).....	16
Хүснэгт 19 Ногоон зээлийн тайлан (сая төгрөгөөр)	18
Хүснэгт 20 Факторингийн тооцооны авлагын ангилал (сая төгрөгөөр)	20
Хүснэгт 21 Бусад хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр)	20
Хүснэгт 22 Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, түрээсийн хөрөнгө, биет бус хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр).....	21
Хүснэгт 23 Пассивын үзүүлэлтүүд (сая төгрөгөөр).....	21
Хүснэгт 24 Итгэлцлийн үйлчилгээ (сая төгрөгөөр)	23
Хүснэгт 25 Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг (сая төгрөгөөр)	24
Хүснэгт 26 Бусад эх үүсвэрийн бүтэц (сая төгрөгөөр)	24
Хүснэгт 27 Төслийн зээл санхүүжилт (сая төгрөгөөр)	25
Хүснэгт 28 Бусад өр төлбөр (сая төгрөгөөр)	26
Хүснэгт 29 Санхүүгийн бус өр төлбөр (сая төгрөгөөр).....	26
Хүснэгт 30 Өөрийн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр)	26
Хүснэгт 31 Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр).....	27
Хүснэгт 32 ХНХ-ийн интервал (тэрбум төгрөгөөр).....	27
Хүснэгт 33 Бусад өмч, сангуудын бүтэц (сая төгрөгөөр).....	28
Хүснэгт 34 Орлого, үр дүнгийн тайлан (харьцуулсан, сая төгрөгөөр)	29
Хүснэгт 35 Орлого, үр дүнгийн тайлан (тэр төгрөгөөр).....	30
Хүснэгт 36 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд (үзүүлэлт бүрээр).....	30
Хүснэгт 37 2025 оны III улирлын байдлаарх валют арилжааны мэдээ (сая төгрөгөөр).....	31

Зургийн жагсаалт

Зураг 1 Банкны салбарт эзлэх хувь (нийт актив, зээл).....	11
Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)	11
Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр).....	12
Зураг 4 Зээлийн багцын чанар (тэрбум төгрөгөөр)	14
Зураг 5 Зээлийн багцын чанар (хувиар)	14
Зураг 6 Олгосон зээл (хугацааны ангиллаар)	15
Зураг 7 Сүүлийн 5 жилийн байдлаар финтек зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөгөөр)	16
Зураг 8 Сүүлийн 3 жилийн байдлаар ногоон зээлийн үлдэгдэл(тэрбум төгрөгөөр).....	18
Зураг 9 Ногоон зээлийн багцын чанар (ногоон таксономийн 12 ангиллаар)	19
Зураг 10 Банкны салбарт эзлэх хувь (өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг).....	22
Зураг 11 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр).....	22
Зураг 12 Итгэлцлийн үйлчилгээний өглөг (тэрбум төгрөгөөр)	23
Зураг 13 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)	25
Зураг 14 Төслийн зээлийн санхүүжилт сүүлийн 5 жилийн байдлаар	25
Зураг 15 Хувьцаат капитал сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр).....	27
Зураг 16 Хуримтлагдсан ашиг/алдагдал (тэрбум төгрөгөөр).....	28
Зураг 17 Тайлант үеийн ашиг/алдагдал (тэрбум төгрөгөөр).....	28
Зураг 18 Ашигт ажиллагааны үзүүлэлт (тэрбум төгрөгөөр).....	29
Зураг 19 Салбарын өгөөжийн үзүүлэлт сүүлийн 5 жилээр	31

Товчилсон нэрсийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ЗГВА	Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг
УБ	Улаанбаатар хот
ХОН	Хөдөө орон нутаг
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗХШҮ	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт
СТ	Санхүүгийн тайлан
ХБҮЦ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
ЗМС	Зээлийн мэдээллийн сан

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал

2025 оны жилийн эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 575 ББСБ байгаа нь өмнөх оны мөн үеэс 2 ББСБ буюу 0.3 хувиар өссөн үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 98 нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 26 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 5 ББСБ байна.

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл

	2021	2022	2023	2024	2025
Шинээр олгосон	14	17	32	60	15
Хүчингүй	12	38	16	17	13
Түдгэлзүүлсэн	29	65	33	23	28
Сэргээсэн	8	34	24	22	8
Нийт ББСБ	534	513	529	573	575
Үүнээс: ХОН	83	93	95	97	98
Үүнээс: ГХО	28	26	24	28	26
Салбар	331	427	446	521	591
Төлөөлөгч	8	8	11	12	10

2025 оны жилийн эцсийн байдлаар 15 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 28 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлж, 8 ББСБ-ын үйл ажиллагааг сэргээж, 13 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгохоос гадна уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2025 оны жилийн эцсийн байдлаар 82 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд (тэрбум төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	2024	2025	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	7,127.3	9,076.7	27.4%
Банкны салбартай харьцуулахад хувиар	10.0%	10.6%	0.6%
Нийт өөрийн хөрөнгө	3,671.3	4,955.4	35.0%
Банкны салбартай харьцуулахад хувиар	53.4%	62.0%	8.6%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	1,790.4	2,233.3	24.7%
Банкны салбартай харьцуулахад хувиар	103.7%	123.2%	19.5%
Нийт зээл	5,750.4	7,216.3	25.5%
Банкны салбартай харьцуулахад хувиар	15.4%	16.2%	0.9%
Нийт орлого	1,828.2	2,718.0	48.7%
Нийт зарлага	1,130.3	1,771.9	56.8%
Цэвэр ашиг	697.9	946.1	35.6%

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 27.4 хувиар өсөж, банкны салбарын 10.6%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 123.2%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19.5 пунктээр өссөн дүн юм.

2025 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 27.4 хувиар буюу 1.9 их наяд төгрөгөөр өсөж 9.1 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 75.2 хувийг зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 65.9 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ББСБ-уудын нийт орлогын хэмжээ 48.7 хувиар буюу 889.8 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 56.8 хувиар буюу 641.6 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 35.6 хувиар буюу 248.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2024	2025	Тоо	Хувь
	Нийт ББСБ-ын тоо	573	575	2	0.3%
1	Зээл	509	512	3	0.6%
	<i>Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>	310	320	10	3.2%
2	Факторингийн үйлчилгээ	55	60	5	9.1%
3	Төлбөрийн баталгаа гаргах	28	29	1	3.6%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	6	7	1	16.7%
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	54	55	1	1.9%
6	Гадаад арилжаа	178	165	(13)	(7.3%)
	<i>Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>	61	60	(1)	(1.6%)
7	Итгэлцлийн үйлчилгээ	91	91	0	-
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	48	56	8	16.7%
9	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	-	-

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 575 ББСБ 9 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 89.0% нь буюу 512 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 55.7% нь буюу 320 ББСБ дагнан эрхэлж байна. Харин гадаад валютын

арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 165 ББСБ байгаа нь нийт ББСБ-уудын 28.7 хувийг, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа 60 ББСБ нийт ББСБ-уудын 10.4 хувийг бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үеэс өөрчлөгдсөн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оноос 10 ББСБ-аар буюу 3.2 хувиар, төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа 1 ББСБ-аар буюу 3.6 хувиар, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ 8 ББСБ-аар буюу 16.7 хувиар, цахим төлбөр

тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ 1 ББСБ-аар буюу 1.9 хувиар өссөн бол факторингийн үйлчилгээ 5 ББСБ-аар буюу 9.1 хувиар, гадаад валютын арилжаа 13 ББСБ-аар буюу 7.3 хувиар буурсан байна.

2025 оны жилийн эцсийн тайлан мэдээний ирц 97.7% байна. Тайлан мэдээг ирүүлбэл зохих 575 ББСБ-аас 562 ББСБ жилийн тайлан мэдээ ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 7 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр, нэр бүхий 6 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 68 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ыг, хоёрдугаар хавсралтаар “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам”-ыг тус тус баталсан. Энэхүү журмаар банк бус санхүүгийн итгэлцлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын хувьд итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа нь 60 хувиас хэтрэхгүй байх, нийт зээлийн багцад эзлэх ногоон зээлийн хэмжээ хоёроос дээш хувь бол итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа нь 65-80 хувь хүртэл байх, бусдаас өрийн бичиг гаргах замаар эх үүсвэр татан төвлөрүүлсэн ББСБ-ын хувьд гаргасан өрийн бичгийг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа нь 30 хувиас хэтрэхгүй байх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан ББСБ-ын хувьд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах замаар эх үүсвэр татан төвлөрүүлэх дүн нь өөрийн хөрөнгийн 60 хувиас хэтрэхгүй байх, мөн ББСБ нь дотоодын арилжааны банк, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдээс зээл болон бусад хэлбэрээр эх үүсвэр татан төвлөрүүлэхгүй байхаар зохицуулсан.

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 77 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”, 78 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-д тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан. Журмын өөрчлөлтийн хүрээнд ББСБ-аас олгох хэрэглээний зээлд өр, орлогын харьцаа болон суудлын автомашин барьцаалсан зээл, зээл үнэлгээний харьцаа 60 хувиас хэтрэхгүй байхаар тус тус өөрчлөлт оруулсан.

3. 2025 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ буюу нэмэлт, өөрчлөлт орсон журмуудын талаар танилцуулах сургалтад нийт 300 гаруй ББСБ-д хамрагдсан.

4. Санхүүгийн зохицуулах хороо Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоотой хамтран ББСБ-уудын удирдлагуудад зориулсан “Банк бус санхүүгийн байгууллагын гүйцэтгэх захирал мэргэшүүлэх сургалт”-ыг 2025 оны 4-р сарын 23-25, 9 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд тус тус зохион байгуулагдсан бөгөөд энэ удаагийн сургалтад Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот, Говь-Алтай, Говьсүмбэр аймгийн 67 ББСБ-ын 70 гүйцэтгэх захирал, удирдлагууд хамрагдсан.

5. Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ний өдрийн 69 дүгээр тогтоолоор банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг Улаанбаатар хотод 5,000,000,000 /таван тэрбум/ төгрөг, Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан, Төв аймгийн Зуунмод суманд 1,200,000,000 /нэг тэрбум хоёр зуун сая/төгрөг, бусад аймаг сумдад 400,000,000 /дөрвөн зуун сая/ төгрөгөөс багагүй байхаар тус тус ялгамжтай тогтоосон. Банк бус санхүүгийн итгэлцлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ 10,000,000,000 /арван тэрбум/ төгрөг байсныг Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 503 дугаар тогтоолоор Улаанбаатар хотод 10,000,000,000 /арван тэрбум/ төгрөг, Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан, Төв аймгийн Зуунмод суманд 2,400,000,000 /хоёр тэрбум дөрвөн зуун сая/ төгрөг

бусад аймаг сумдад 800,000,000 /найман зуун сая/ төгрөг байхаар тус тус өөрчлөн тогтоосон.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт

2025 оны байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 95.6 хувь буюу 548 ББСБ, нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлэн ажилласан байна.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ууд нь Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах, гэрээ байгуулж мэдээлэл солилцох үүрэгтэй.

2025 оны жилийн эцсийн байдлаар зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 512 ББСБ-ын 97.5 хувь буюу 499 ББСБ Монголбанк, “Бүрэн скор ЗМС” ХХК болон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК-ийн аль нэгтэй гэрээ байгуулсан байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д

заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 119 ББСБ, 38,193 удаагийн тохиолдлоор, 4,057.6 тэрбум төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ” гэж заасны дагуу нэр бүхий 12 ББСБ, 5,806 удаагийн тохиолдлоор, 52.6 тэрбум төгрөгийг Монголбанкны СМА-д тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 572 ББСБ-аас 1,455.9 сая төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төвлөрүүлэхээс 100.8% буюу 570 ББСБ 1,469.5 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

Статистик үзүүлэлтүүд

2025 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 41,762 хувьцаа эзэмшигчдийн 575 ББСБ, 591 салбар нэгж, 10 төлөөлөгчийн газар, 6,578 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 4.1 сая харилцагчид үйлчилгээ үзүүлж, 3.2 сая зээлдэгчид /давхардаагүй 752,736/ хүрч үйлчилж байна.

Харилцагчид, зээлдэгчид

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 23.9 хувиар буурч давхардсан тоогоор 4,102,801 зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 36.6 хувиар өсөж 3,153,503-т хүрсэн байна.

Хүснэгт 4 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл

Статистик мэдээлэл	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Нийт харилцагчдын тоо	4,102,801	2,973,618	418,282	3,684,519	163,519	4,044,769	58,032	475,946	107,571
Үүнээс: Эмэгтэй	2,166,871	1,558,689	219,310	1,947,561	74,397	2,136,194	30,677	257,307	55,680
Эрэгтэй	1,915,443	1,413,572	179,707	1,735,736	71,571	1,888,151	27,292	218,236	51,443
Хуулийн этгээд	20,487	1,357	19,265	1,222	17,551	20,424	63	403	448
Итгэмжлэгчдийн тоо	15,588	15,584	795	14,793	-	15,531	57	6,683	406
Өрийн бичиг авсан харилцагчдын тоо	1,887	1,845	158	1,729	-	1,887	-	606	-
Зээлдэгчдийн тоо	3,153,503	2,363,497	120,682	3,032,821	39	3,101,084	52,419	227,691	107,568
Хэвийн	2,763,018	2,086,868	97,777	2,665,241	17	2,724,339	38,679	184,004	89,662
Хугацаа хэтэрсэн	118,083	82,764	4,158	113,925	-	115,093	2,990	10,777	3,981
Чанаргүй:	272,402	193,865	18,747	253,655	22	261,652	10,750	32,910	13,925
-Хэвийн бус	77,700	56,003	4,313	73,387	4	74,949	2,751	8,775	3,792
-Эргэлзээтэй	112,902	83,145	3,712	109,190	1	108,649	4,253	17,350	8,393
-Муу	81,800	54,717	10,722	71,078	17	78,054	3,746	6,785	1,740
Зээлдэгчдийн насжилт	3,147,154	2,357,843	119,673	3,027,481	39	3,094,792	52,362	227,022	106,861
18-25 насны	539,843	375,167	13,815	526,028	20	531,079	8,764	33,131	13,122
26-35 насны	1,257,511	930,317	36,537	1,220,974	19	1,235,722	21,789	85,289	40,680
36-45 насны	880,339	681,590	40,115	840,224	-	866,957	13,382	68,843	32,300
46-55 насны	384,344	301,232	21,270	363,074	-	377,811	6,533	29,444	14,453
55-аас дээш	85,117	69,537	7,936	77,181	-	83,223	1,894	10,315	6,306
Зээлдэгчдийн боловсрол	3,147,195	2,357,843	119,714	3,027,481	39	3,094,833	52,362	227,022	106,867
-Дээд	1,575,730	1,171,625	55,579	1,520,151	20	1,549,724	26,006	130,979	68,482
-Тусгай дунд	327,482	212,973	8,180	319,302	19	322,159	5,323	22,122	14,617
-Бүрэн дунд	879,114	652,078	34,166	844,948	-	860,810	18,304	57,882	14,627
-Дунд	269,117	234,924	14,970	254,147	-	267,418	1,699	13,004	6,618
-Бага	95,753	86,244	6,819	88,934	-	94,723	1,030	3,036	2,524

(Финтек ББСБ-ууд цахим, уламжлалт зээл хослуулан олгодог болно)

Нийт харилцагчдын 89.8% буюу 3,684,519 зээлдэгчдийн 96.2% буюу 3,032,821 нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж (финтек), онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа бол нийт харилцагчдын 10.2% буюу 418,282 зээлдэгчдийн 3.8% буюу 120,682 нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгч байна. Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын харилцагчид 163,519 буюу нийт харилцагчдын 4.0 хувийг бүрдүүлж байна.

Хувьцаа эзэмшигчид болон ажилчид

Хүснэгт 5 Статистик мэдээлэл (5 жилээр)

Үзүүлэлтүүд	2021	2022	2023	2024	2025	Өөрчлөлт	
						Дүнгээр	Хувиар
Хувьцаа эзэмшигчдийн тоо	21,793	26,993	30,419	34,973	41,762	6,789	19.4%
Ажилчдын тоо	3,976	4,554	5,855	5,964	6,578	614	10.3%
Харилцагчдын тоо	4,820,624	4,633,616	4,535,672	5,393,028	4,102,801	(1,290,227)	(23.9%)
Зээлдэгчдийн тоо	1,678,139	1,187,603	1,600,427	2,308,525	3,153,503	844,978	36.6%
Зээлийн жигнэсэн дундаж хүү	2.7%	3.1%	3.3%	3.5%	3.7%	0.2%	

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеэс 19.4 хувиар буюу 6,788-аар өсч 41,761-т хүрчээ. Нийт хувьцаа эзэмшигчдийн 97.2 хувь буюу 40,606 нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-уудын хувьцаа эзэмшигч байгаа бол 1,155 буюу 2.8% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн 3,144 буюу 7.5% нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байгаа бол 215 буюу 0.5% нь хөдөө орон нутгийн ББСБ-уудын хувьцаа

эзэмшигчид байна. ББСБ-ын салбарын нийт ажилтнуудын тоо өмнөх оны мөн үеэс 10.3 хувиар буюу 614 ажилтнаар нэмэгдэж 6,578-д хүрсэн байна.

Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хувьцаа эзэмшигчдийн тоо	41,762	40,846	1,919	39,843	81	41,547	215	40,625	3,144
Нийт ажилтнуудын тоо	6,578	4,217	2,523	4,055	146	6,277	301	615	493
Үүнээс: Эмэгтэй ажилтны тоо	3,938	2,507	1,505	2,433	83	3,742	196	391	299
Эрэгтэй ажилтны тоо	2,640	1,710	1,018	1,622	63	2,535	105	224	194

Хөдөө орон нутгийн 98 ББСБ 7 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа

	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ТЗ-тэй ББСБ-ын тоо	575	91	493	82	60	477	98	5	570	26
1 Зээл	512	91	430	82	-	419	93	5	507	25
2 Факторингийн үйлчилгээ	60	37	27	33	-	56	4	3	57	1
3 Төлбөрийн баталгаа гаргах	29	15	17	12	-	28	1	3	26	3
4 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	7	6	-	7	-	7	-	1	6	-
5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	55	26	28	27	-	53	2	3	52	2
6 Гадаад валютын арилжаа	165	35	134	31	60	149	16	5	160	9
7 Итгэлцлийн үйлчилгээ	91	91	45	46	-	87	4	5	86	5
8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	56	34	28	28	-	53	3	3	53	3
9 Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	1	-	-	1	-	-	1	1

Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 83.0% буюу 477 ББСБ, салбаруудын 58.9% буюу 348 салбар байршиж байна. Харин хөдөө орон нутагт нийт ББСБ-ын 17.0% буюу 98 ББСБ, салбаруудын 40.9% буюу 242 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар 120 ББСБ-ын 591 салбар бүртгэлтэй байгаа ба эдгээрийн 57.4 хувийг 15 ББСБ-ын 339 салбар бүрдүүлж байна. Мөн Австрали улсад 1 салбар бүртгэлтэй байна.

Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт

Дүүрэг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	477	348	825	100.0%
1. Сүхбаатар	160	46	206	25.0%
2. Чингэлтэй	123	29	152	18.4%
3. Баянзүрх	58	86	144	17.5%
4. Баянгол	67	46	113	13.7%
5. Хан-Уул	60	51	111	13.5%
6. Сонгинохайрхан	8	77	85	10.3%
7. Багануур	1	7	8	1.0%
8. Налайх	-	6	6	0.7%

ББСБ-ууд хөдөө орон нутгаас Орхон, Дархан-Уул, Төв, аймгуудад, Улаанбаатар хотоос Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдэд хамгийн ихээр төвлөрч үйлчилгээгээ хүргэж байна.

Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт

Аймаг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	98	242	340	100%
Архангай аймаг	2	7	9	2.8%
Баян-Өлгий аймаг	3	6	9	2.6%
Баянхонгор аймаг	4	11	15	4.4%
Булган аймаг	2	2	4	1.2%
Говь-Алтай аймаг	1	4	5	1.5%
Говьсүмбэр аймаг	3	4	7	2.1%
Дархан-Уул аймаг	9	24	33	9.7%
Дорноговь аймаг	3	13	16	4.7%
Дорнод аймаг	6	20	26	7.6%
Дундговь аймаг	0	9	9	2.6%
Завхан аймаг	2	8	10	2.9%
Орхон аймаг	9	23	32	9.4%
Өвөрхангай аймаг	9	16	25	7.4%
Өмнөговь аймаг	2	22	24	7.1%
Сүхбаатар аймаг	5	8	13	3.8%
Сэлэнгэ аймаг	9	13	22	6.5%
Төв аймаг	21	11	32	9.4%
Увс аймаг	2	10	12	3.5%
Ховд аймаг	1	9	10	2.9%
Хөвсгөл аймаг	2	10	12	3.5%
Хэнтий аймаг	3	12	15	4.4%

Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


2025 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 9.1 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.4 хувиар буюу 1.9 их наяд төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 75.2 хувийг нийт зээлийн өсөлт бүрдүүлж байна. Активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд (сая төгрөгөөр)

Активын үзүүлэлтүүд	2024		2025		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Дүн	Хувь	Дүн
САНХҮҮГИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,808,616.4	95.5%	8,653,821.5	6,808,616.4	95.5%	8,653,821.5
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	825,758.2	11.6%	1,048,106.3	825,758.2	11.6%	1,048,106.3
Хөрөнгө оруулалт	68,276.5	1.0%	143,897.1	68,276.5	1.0%	143,897.1
Зээл (цэврээр)	5,703,636.1	80.0%	7,089,370.0	5,703,636.1	80.0%	7,089,370.0
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	54,281.8	0.8%	99,569.1	54,281.8	0.8%	99,569.1
Үүсмэл санхүүгийн хөрөнгө	583.1	0.0%	15,818.1	583.1	0.0%	15,818.1
Бусад санхүүгийн хөрөнгө	156,080.8	2.2%	257,060.9	156,080.8	2.2%	257,060.9
САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	318,658.6	4.5%	422,914.7	318,658.6	4.5%	422,914.7
Санхүүгийн бус бусад хөрөнгө	122,285.6	1.7%	180,884.3	122,285.6	1.7%	180,884.3
Үндсэн хөрөнгө (цэврээр)	140,640.3	2.0%	175,401.5	140,640.3	2.0%	175,401.5
Биет бус хөрөнгө (цэврээр)	55,732.6	0.8%	66,628.9	55,732.6	0.8%	66,628.9
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,127,275.0	100.0%	9,076,736.2	7,127,275.0	100.0%	9,076,736.2


2025 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-уудын нийт актив банкны салбарын нийт активын 10.6 хувьтай, нийт зээлийн үлдэгдэл 16.2 хувьтай тэнцэж байна.

Зураг 1 Банкны салбарт эзлэх хувь (нийт актив, зээл)



Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2020 оны жилийн эцэст 2,006.9 тэрбум төгрөг байсан бол 2025 оны жилийн эцсийн байдлаар 4.5 дахин өсөж 9,076.7 тэрбум төгрөгт хүрчээ. Энэ нь нийт зээлийн үлдэгдэл 5.4 дахин өссөнтэй холбоотой.

Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Салбарын нийт хөрөнгийн 98.5% нь 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 413 ББСБ, 0.5% нь 1.9-2.5 тэрбум төгрөг хүртэлх активтай 21 ББСБ байгаа бол нийт салбарын хөрөнгийн 1.0 хувийг 1.9 тэрбум төгрөг хүртэлх активтай 141 ББСБ-ын хөрөнгө бүрдүүлж байна.

Хүснэгт 11 Активын интервал (тэрбум төгрөгөөр)

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	8,202.9	201	90.4%	35.0%	29.8	3	26.4	4	-	-
2.5-5.0 тэрбум	736.8	212	8.1%	36.9%	4.2	1	4.0	1	5.8	2
1.9-2.5 тэрбум	47.6	21	0.5%	3.7%	2.0	1	11.1	5	-	-
1.4-1.9 тэрбум	23.3	14	0.3%	2.4%	6.9	4	7.8	5	3.3	2
0.6-1.4 тэрбум	37.6	42	0.4%	7.3%	8.6	9	17.6	20	10.0	12
0.6 тэрбум хүртэлх	28.5	85	0.3%	14.7%	-	-	13.6	45	16.0	44
НИЙТ	9,076.7	575	100.0%	100.0%	51.5	18	80.4	80	35.1	60

Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын актив 5.3 их наяд төгрөг байгаа нь нийт активын 58.5 хувийг, нийт зээлийн үлдэгдэл 4.3 их наяд төгрөг байгаа нь нийт зээлийн үлдэгдлийн 60.2 хувийг бүрдүүлж байна.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө


Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 222.3 тэрбум төгрөгөөр буюу 26.9 хувиар өсч 1,048.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Бүтцээр нь авч үзвэл 7.7 хувь нь бэлэн мөнгө хэлбэрээр, 73.5 хувь нь 3 хүртэлх сарын хугацаатай банк, санхүүгийн байгууллагад, 18.0 хувь нь 3-аас дээш сарын хугацаатай банк, санхүүгийн байгууллагад, 0.8 хувь нь мөнгөн хөрөнгөд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага байна.

Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,048.1	676.2	422.3	625.8	31.9	1,025.5	22.7	203.4	191.8
Бэлэн мөнгө	80.7	9.3	70.6	10.1	23.2	73.9	6.7	4.2	5.1
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө (3 хүртэлх сарын хугацаатай)	770.1	509.2	282.2	487.9	8.1	757.7	12.4	172.2	162.5
Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	8.8	8.3	4.9	3.9	0.0	8.8	-	-	-
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө (3-аас дээш сарын хугацаатай)	188.5	149.5	64.7	123.9	0.6	185.0	3.5	27.0	24.2

ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 16.7%, финтек ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 1.6%, эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос хамаарч гадаад валютын арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын 72.7% нь бэлэн мөнгө хэлбэрээр тус тус байршиж байна.

Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 110.8 хувиар буюу 75.6 тэрбум төгрөгөөр өсөж, 2025 оны жилийн эцсийн байдлаар 49 ББСБ 143.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан байна. Хөрөнгө оруулалтын 7.6 хувь буюу 11.0 тэрбум төгрөг нь хадгаламжийн сертификат, 92.4 хувь буюу 132.9 тэрбум төгрөг нь үнэт цаасаарх хөрөнгө оруулалт байна.

Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл	Уламж- лалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	143,897.1	131,950.3	13,245.1	130,652.0	1.0	142,495.0	1,402.2	65,002.9	51,011.5
Хадгаламжийн сертификат	10,995.5	8,495.5	3,916.9	7,078.6	-	10,995.5	-	-	-
Үнэт цаас	132,901.7	123,454.9	9,328.3	123,573.4	1.0	131,499.5	1,402.2	65,002.9	51,011.5
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас	63,328.6	56,914.8	6,295.2	57,033.4	-	61,926.4	1,402.2	13,738.7	500.0
Хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн үнэт цаас	35,306.6	35,054.6	252.0	35,054.6	1.0	35,306.6	-	27,075.4	27,075.4
Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас	33,713.0	31,011.3	2,701.8	31,011.3	-	33,713.0	-	24,436.3	23,683.6
Барьцаанд байгаа үнэт цаас	-	-	-	-	-	-	-	-	-
Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	1,028.0	948.7	79.3	948.7	-	1,028.0	-	227.1	227.1
(Үнэт цаасны эрсдэлийн сан)	474.6	474.6	-	474.6	-	474.6	-	474.6	474.6

2025 оны жилийн эцсийн байдлаар богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх зөвшөөрөлтэй 55 ББСБ бүртгэлтэй байгаа хэдий ч 49 ББСБ санхүүгийн тайлангаар хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан ба эдгээрийн 35 ББСБ нь тусгай зөвшөөрөлтэй байна.

Зээл

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 25.9 хувь буюу 1.5 их наяд төгрөгөөр өсөж 2025 оны жилийн эцсийн байдлаар 7.5 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 422.5 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 7.1 их наяд төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 14 Зээлийн бүтэц (тэрбум төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Зээл (цэврээр)	7,089.4	5,460.5	2,055.7	5,033.7	2.2	6,995.4	94.0	1,069.1	738.0
Зээл	7,512.2	5,757.7	2,191.0	5,321.2	2.3	7,411.6	100.6	1,146.1	784.4
Хэвийн	6,292.1	4,880.4	1,801.6	4,490.4	1.8	6,208.0	84.0	952.7	647.9
Анхаарал хандуулах	318.6	253.6	84.3	234.2	-	314.8	3.8	50.9	37.2
Чанаргүй зээл	605.6	429.2	187.8	417.9	0.1	595.9	9.8	101.7	70.5
-Хэвийн бус зээл	166.7	120.9	44.4	122.3	0.1	164.0	2.7	28.3	16.9
-Эргэлзээтэй зээл	232.5	184.0	51.5	181.1	0.0	229.4	3.2	48.6	32.7
-Муу зээл	206.4	124.4	91.9	114.5	0.0	202.5	3.9	24.8	20.9
(ЗЭС)	422.5	296.9	135.3	287.3	0.1	415.8	6.7	76.8	46.1
Хойшлогдсон төлбөр	5.4	5.3	0.1	5.3	-	5.4	0.0	2.8	2.8
Зээлд хур/тооцсон хүүгийн авлага	301.3	199.8	117.3	184.0	0.4	298.3	3.0	43.6	31.6
ЗЗ-ийн хүүнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга	0.3	0.3	0.0	0.3	-	0.3	-	0.3	0.3

(Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно)


Шинэчлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн журамд зааснаар “Санхүүгийн тайланд зээлийг хорогдуулсан өртгөөр хэмжиж, тайлангана. Зээлийн хорогдуулсан өртөг нь зээлийг анх хүлээн зөвшөөрч хэмжсэн дүнгээс буцаан төлсөн зээлийн үндсэн төлбөрийн

төлөлтийг хасаж, хойшлогдсон орлого, зардлыг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулан хуримтлуулсан дүнг хасах, эсхүл нэмж, зээлийн эрсдэлийн санг хассан дүн байна” гэж тодорхойлсон.

Гадаад валютын арилжаа эрхэлдэг нэр бүхий ББСБ-ын 1.9 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь тус ББСБ-ын зээлийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг 2024 оны 03 сарын 20-ны 119 дүгээр тогтоолоор хүчингүй болгосонтой холбоотойгоор тайланд үлдэгдэл хэлбэрээр туссан болно.

Тайлант хугацаанд ББСБ-ууд 15.1 их наяд төгрөгийн зээлийг 3.7 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 13.7 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2025 оны жилийн эцсийн байдлаар 3.2 сая зээлдэгчийн 7.2 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.


Зураг 4 Зээлийн багцын чанар (тэрбум төгрөгөөр)



(Нийт зээлийн үлдэгдлийг зээлийн багцын нийлбэрээр тооцсон)

Зээлийн багцын 87.2 хувийг буюу 6.3 их наяд төгрөгийг хэвийн зээл, 4.4 хувийг буюу 318.6 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 8.4 хувийг буюу 605.6 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Зураг 5 Зээлийн багцын чанар (хувиар)



Нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь өмнөх оны мөн үеэс 3.6 пунктээр буурсан бол, чанаргүй зээлийн хувь 2.3, анхаарал хандуулах зээлийн хувь 1.3 пунктээр тус тус өссөн байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 924.2 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 45.7 хувьд буюу 422.5 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар нийт зээлд эзлэх анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ 12.8% байна.

Олгосон зээлийн 91.5 хувь буюу 13.8 их наяд төгрөгийн зээлийг иргэдэд, 8.5 хувь буюу 1.3 их наяд төгрөгийн зээлийг хуулийн этгээдэд олгосон байгаа бол 92.5 хувь буюу 12.7 их наяд төгрөг нь иргэдээс, 7.5 хувь нь буюу 1.0 их наяд төгрөг нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар 7.2 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа ба үүний 88.5 хувь буюу 6.4 их наяд төгрөгийг иргэдийн, 11.5 хувь буюу 830.0 тэрбум төгрөгийг хуулийн этгээдийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.


Хүснэгт 15 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар (сая төгрөгөөр)

№	Зээлийн эдийн засгийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	63,225.0	0.4%	56,659.2	0.4%	74,318.1	1.0%
2.	Уул уурхай, олборлолт	72,488.5	0.5%	65,758.9	0.5%	87,476.6	1.2%
3.	Боловсруулах үйлдвэрлэл	77,004.7	0.5%	68,139.3	0.5%	59,759.8	0.8%
4.	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	12,730.2	0.1%	10,393.2	0.1%	12,735.8	0.2%
5.	Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	8,800.2	0.1%	7,590.3	0.1%	6,876.2	0.1%
6.	Барилга	366,766.8	2.4%	336,724.0	2.5%	332,861.1	4.6%
7.	Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	1,019,410.5	6.7%	856,427.4	6.2%	832,296.0	11.5%
8.	Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	270,224.3	1.8%	304,068.6	2.2%	173,954.9	2.4%
9.	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	101,082.8	0.7%	103,990.7	0.8%	114,660.2	1.6%
10.	Мэдээлэл, холбоо	38,069.3	0.3%	39,746.1	0.3%	33,646.4	0.5%
11.	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	293,727.8	1.9%	229,865.4	1.7%	134,895.7	1.9%
12.	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	204,174.1	1.4%	170,187.5	1.2%	96,675.9	1.3%
13.	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	8,917.5	0.1%	9,823.9	0.1%	9,196.5	0.1%
14.	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	17,747.1	0.1%	21,154.4	0.2%	18,175.6	0.3%
15.	Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	9,807.9	0.1%	9,660.1	0.1%	11,895.3	0.2%
16.	Боловсрол	55,634.2	0.4%	47,030.7	0.3%	39,992.1	0.6%
17.	Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	29,052.1	0.2%	27,172.2	0.2%	27,195.7	0.4%
18.	Урлаг, үзвэр, тоглоом наадам	11,169.1	0.1%	6,824.6	0.0%	11,333.8	0.2%
19.	Бусад	12,457,231.5	82.4%	11,335,441.7	82.7%	5,138,327.5	71.2%
Иргэнд олгосон зээл		13,827.6	91.5%	12,681.0	92.5%	6,386.2	88.5%
Хуулийн этгээдэд олгосон зээл		1,289.7	8.5%	1,025.6	7.5%	830.0	11.5%
НИЙТ		15,117,263.7	100%	13,706,658.1	100%	7,216,273.2	100%

Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319/А/16 тоот тушаалаар баталсан “[Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал](#)”-аар нийт олгосон зээлийн 82.4% буюу 12.4 их наяд төгрөг нь бусад ангилалд (ихэвчлэн хэрэглэний зээл), 6.7% буюу 1.0 их наяд төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 82.7% буюу 11.3 их наяд төгрөг нь бусад ангиллын зээлээс, 6.2% буюу 856.4 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээлээс төлөгджээ.

Тайлант улиралд олгосон зээлийг хугацааны ангиллаар харвал 1 сар хүртэлх хугацаатай олгосон зээл нийт зээлийн 25.7 хувийг, 1-3 сарын хугацаатай олгосон зээл нийт зээлийн 13.1 хувийг, 6-12 сарын хугацаатай олгосон зээл нийт зээлийн 19.9 хувийг, 1-5 жил хүртэлх хугацаатай олгосон зээл тус тус нийт зээлийн 35.6 хувийг буюу хамгийн өндөр хувийг бүрдүүлж байна.

Зураг 6 Олгосон зээл (хугацааны ангиллаар)



Нийт зээлийн үлдэгдлийн ангиллаас харахад 7.2 их наяд төгрөгийн зээлийн 52.0 хувийг иргэний хэрэглээний зээлийн үлдэгдэл, үүнээс 19.4 хувийг автомашинд зориулсан зээлийн үлдэгдэл, 30.6 хувийг хуулийн этгээдийн болон иргэнд олгосон бизнесийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Хүснэгт 16 Зээлийн ангилал (тэрбум төгрөгөөр)

Зээлийн ангиллаар	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь
Иргэнд олгосон зээл	13,827.6	91.5%	12,681.0	92.5%	6,386.2	88.5%
Хэрэглээнд зориулсан зээл	9,419.5	62.3%	9,157.5	66.8%	3,755.7	52.0%
Үүнээс: Автомашинд зориулсан зээл	1,063.6	7.0%	1,216.0	8.9%	1,399.0	19.4%
Бизнес зориулсан зээл	2,032.0	13.4%	1,531.3	11.2%	1,508.4	20.9%
Үл хөдлөх эд хөрөнгөд зориулсан зээл	157.5	1.0%	151.3	1.1%	165.0	2.3%
Бусад зээл	2,218.6	14.7%	1,841.0	13.4%	957.1	13.3%
Хуулийн этгээдэд олгосон зээл	1,289.7	8.5%	1,025.6	7.5%	830.0	11.5%
Бизнесийн зээл	1,041.2	6.9%	828.0	6.0%	700.5	9.7%
Автомашинны зээл	6.7	0.0%	8.5	0.1%	11.2	0.2%
Үл хөдлөх эд хөрөнгийн зээл	28.0	0.2%	26.7	0.2%	10.3	0.1%
Бусад зээл	213.7	1.4%	162.4	1.2%	108.0	1.5%
НИЙТ	15,117.3	100%	13,706.7	100%	7,216.3	100%

Цахим зээл


Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй 82 ББСБ 75 финтек зээлийн аппликэйшнээр дамжуулж цахим зээлийн үйлчилгээ үзүүлж байна.

Хүснэгт 17 Зээлийн ангилал (мянган төгрөгөөр)

	Зээлийн дүн	Нийт дүнд эзлэх хувь	Зээлдэгчдийн тоо	Нийт дүнд эзлэх хувь	Дундаж зээл
Уламжлалт	4,931,131,535.8	68.3%	313,104	9.9%	15,749.2
Цахим зээл	2,285,141,625.2	31.7%	2,840,399	90.1%	804.5
Нийт	7,216,273,161.1	100.0%	3,153,503	100.0%	2,288.3

2025 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-ууд зөвхөн аппликэйшний 2.8 сая зээлдэгчийн 2.3 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт зээлдэгчийн 90.1 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 31.7 хувийг бүрдүүлж байна. Зөвхөн аппликэйшнээр нэг зээлдэгчид дунджаар 804.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь уламжлалт зээлийн дунджаас 19.6 дахин бага байна.

Зураг 7 Сүүлийн 5 жилийн байдлаар финтек зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөгөөр)



Өмнөх оны мөн үеэс финтек зээлдэгчийн тоо 62.4 хувиар өсөн 2,840,399-г хүрч, зээлийн үлдэгдлийн хэмжээ 69.3% буюу 0.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Цахим зээлийн мэдээлэл ирүүлээгүй 12 ББСБ-уудад холбогдох арга хэмжээг авах шаардлагатай байна.

Хүснэгт 18 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд (мянган төгрөгөөр)

№	Финтек	App нэр	Бүртгүүлсэн огноо
1	Соно финтек	Sono Mongolia	2023.03.03-№7/895
2	Покет	Pocket.mn	2023.05.08-№7/1871
3	Мобифинанс	Monpay	2023.06.20-№7/2540
4	Прогресс финтек	Zuut	2024.05.30-№7/2044
5	Тус финтек	Tus fintech	2023.05.19-№7/2125
6	Анлок капитал	Unlock Finance	2024.04.23-№7/1442
7	Таван богд финанс	PayOn.mn	2023.07.04-№7/2826
8	Лэндмн	LendMN	2023.06.20-№7/2550
9	Нөмөр кредит	Numur	2023.03.03-№7/890
10	Ашид капитал	Simple.mn	2023.11.10-№7/4317
11	ТОКИ	Toki	2023.06.20-№7/2549
12	Инвескор	InvesCore	2023.08.25-№7/3350
13	Нэт капитал финанс корпораци	NetPay	2023.07.04-№7/2825
14	Омни капитал	Moni	2023.07.05-№7/2869
15	Ардкредит	Ard	2023.12.22-№7/4873
16	Хатан суудал инвест	Zeely	2023.03.03-№7/894
17	Сэндли	Sendly	2023.07.04-№7/2821
18	Соломон инвестментс	M credit	2023.11.10-№7/4319
19	Жи Эс Би Капитал	Prime	2024.02.21-№7/631
20	Үнэт кредит	Valu up	2025.04.30-№3/1598
21	Ньюстар финанс	Nsf.mn	2023.06.20-№7/2552
22	Дэвжих нэхий	Money-T	2023.12.22-№7/4870
23	Си и си инвестмент	Pocket.mn	2024.04.24
24	Номин юнити	OmniWay	2024.02.21-№7/634
25	Гэрэлфинанс	Gerel	2023.05.08-№7/1872
26	Очир ундраа ОМЗ	Opay MN	2023.08.25-№7/3351
27	Бизнес-Инвест девелопмент	BiD	2023.08.25-№7/3353
28	Мөнгөнзоос кредит	Pocket.mn	2023.05.24
29	Навитгас фанд	Pocket.mn	2025.02.03
30	Кэйш флов финанс	Tugrug App	2024.02.21-№7/632
31	Зөгий санхүүгийн групп	Pocket.mn	7/21/2025
32	Цогзолфинанс	Pocket.mn	2023.05.23
33	Микрокредит	Easy	2023.12.22-№7/4871
34	Сэнд эм эн	SendMN	2024.02.21-№7/636
35	Энт кредит инвестмент	EntCreditMN	2023.03.03-№7/891
36	Финруут-Инвестмент	Pocket.mn	2023.05.24
37	Есөн финанс	MetaLend	2023.08.25-№7/3352
38	Мэйн стрит финанс	Pays	2025.02.11-№3/425
39	Грийн-Инвестмент	Gate.mn	2023.07.04-№7/2827
40	БСБ финанс	BSB Finance	2025.02.11-№3/427
41	Монголиан юнайтед кредит	UniPay.mn	2024.12.04-№7/3979
42	Хас хаан	ХАСХААН	2023.06.20-№7/2551
43	Төвхөн ингүүмэл	Oneclick.mn	2024.07.09-№7/2534
44	Финко капитал	Beep	2024.09.23-№7/3172
45	Сагоши накамото	Cash24	2025.09.02-№7/3282
46	Алтан зоос капитал	ZOOS	2024.05.30-№7/2046
47	Их монгол кредит	Ikh Mongol Credit	2024.02.21-№7/633
48	Авто зээл платформс	Valu up	2025.09.16
49	Централ капитал	Kmobimn	2024.04.23-№7/1441
50	Фингейт эм эн	M credit	7/3/2025
51	Инвеско фанд	IF.mn	2023.08.25-№7/3349
52	Изи пэй норбула	Easyway.mn	2023.12.22-№7/4867
53	Жи Би Си Си	E-zeel	2023.03.03-№7/889
54	Их ирээдүй капитал	Easy loan	2024.05.30-№7/2043
55	Хексинг финанс	Sign Finance	2024.12.04-№7/3980
56	Девелопинг энтрепренюриал монголиа	DEM.mn	2024.05.30-№7/2045
57	Монголиа импакт финанс	Qmoni	2023.08.25-№7/3356
58	Гурван зуун жар файнанс	Minu pay	2023.07.04-№7/2822
59	Нанокапитал	Nano Capital	2023.07.04-№7/2824
60	Зээл Эм Эн платформ	Zeel.mn	2023.07.04-№7/2828
61	Вишнфанд	Вишнфанд	2024.12.04-№7/3982
62	Өсөх ундарга финанс	Ufinance	2024.09.23-№7/3171
63	Тапапэй	Tapa	2024.09.24-№7/3174
64	Улаанбаатар кредит	Uray	2024.12.16-№7/4110
65	Эм Эл Жи капитал	ANDA	2024.07.09-№7/2536
66	Хангууд финанс	Khanguud	2023.12.22-№7/4872

67 Мандал дижитал кредит	Car zeel	2025.09.03.-№7/3308
68 Монкор финанс	Cash pay	2024.07.09-№7/2535
69 Дарь финанс	Money mate	2025.06.18-№7/2427
70 Онч-Энх	Ugloo	2023.03.30-№7/1297
71 Бэрс финанс	Bers Pay	2025.10.21-№7/3854
72 Франкфурт капитал	Nar app	2023.07.04-№7/2823
73 Магна профит энд инвестмэнт	Magna.mn	2024.02.21-№7/635
74 Бүрэнфинанс	Buren zeel	2025.10.17-№7/3819
75 Бичил глобус финанс	BG pay	2025.10.21-№7/3853
76 Прогресскапитал	ProgressPay	2025.10.10-№7/3737
77 ЛэндМН СМЭ	LendMN	7/28/2025
78 Балансэд кредит	Balance	2024.12.04-№7/3981
79 Гоулдман инвестмент групп	Goldpay	2023.08.25-№7/3355
80 Есөн эрдэнэ финанс	Leasing.mn	2023.03.30-№7/1298
81 Монголын ногоон санхүүгийн корпораци	Мост мони	2024.12.25
82 Говьфинанс	CashOne	2023.08.25-№7/3354

/"Инвескор ББСБ" ХК-ийн Pocket аппликэйшнд бүртгэлтэй 10 ББСБ байна.
Зөвхөн аппликэйшнээр зээл олгож байгаа 6 ББСБ-ыг шараар тэмдэглэв/

Ногоон зээл

Тайлант хугацаанд 43 ББСБ 27,621 зээлдэгчид 180.4 тэрбум төгрөгийн зээлийг дунджаар 2.9 хувийн хүүтэйгээр олгож, 44 ББСБ-ын 19,078 зээлдэгчээс 144.9 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2025 оны жилийн эцсийн байдлаар 47 ББСБ 15,129 зээлдэгчийн 152.7 тэрбум төгрөгийн “ногоон” зээлийн үлдэгдэлтэй гарчээ. Энэ нь салбарын нийт зээлийн үлдэгдлийн 2.1%-тай тэнцэж байна.

Хүснэгт 19 Ногоон зээлийн тайлан (сая төгрөгөөр)


	НОГООН ТАКСОНОМИ ҮНДСЭН 12 АНГИЛАЛ	Олгосон зээлийн		Төлөгдсөн зээлийн		Зээлийн эцсийн үлдэгдлийн	
		Дүн	Зээлдэгч- дийн тоо	Дүн	Зээлдэгч- дийн тоо	Дүн	Зээлдэгч- дийн тоо
Ногоон	1. Эрчим хүчний хангамж, дэд бүтэц	1,354.6	47	851.0	48	1,400.2	26
	2. Эрчим хүчний үр ашиг	38,526.6	18,662	18,520.5	12,075	32,079.7	7,746
	3. Тогтвортой хот төлөвлөлт ба барилга	21,150.0	485	20,781.2	411	27,738.7	1,197
	4. Бохирдлыг бууруулах ба сэргийлэх	115.8	265	172.6	125	66.5	147
	5. Тогтвортой ус, хог хаягдал	2,891.9	88	2,857.3	53	985.3	72
	6. Тогтвортой хөдөө аж, ахуй	18,230.7	516	13,677.9	504	9,752.1	489
	7. Тогтвортой газар ашиглалт ба биологийн олон янз байдал	6,964.7	67	6,752.2	116	6,396.7	303
	8. Нүүрс хүчлийн хийн ялгарал багатай тээвэр	55,243.8	3,190	54,156.4	3,592	46,275.8	2,101
	8.1.Цахилгаан тээврийн хэрэгсэл	31,752.7	2,756	28,454.4	2,407	15,540.6	1,136
	8.2.Хосолсон хөдөлгүүрт тээврийн хэрэгсэл	14,922.3	359	12,874.4	793	22,664.6	578
	8.3.Хэмнэлттэй тээврийн хэрэгсэл	661.2	3	1,184.3	320	6,027.7	320
	8.4.Дугуй, скүүтэр	189.1	6	3.2	2	188.1	5
8.5.Бусад	7,718.4	66	11,640.2	70	1,854.8	62	
Нийгэм	9. Мэдээлэл, харилцаа холбоо, технологи	6,597.4	3,534	5,700.5	1,486	3,501.0	2,238
	10. Эрүүл мэнд	16,572.6	376	7,479.2	234	11,711.8	378
	11. Боловсрол, Соёл	11,497.7	378	7,716.5	407	9,303.0	412
	12. Хүртээмжтэй дэд бүтэц	1,309.1	13	6,262.2	27	3,527.4	20
	НИЙТ	180,455.01	27,621	144,927.7	19,078	152,738.3	15,129

Ногоон зээлийн үлдэгдлийн 30.3% буюу 46.3 тэрбум төгрөгийг нүүрс хүчлийн хийн ялгарал багатай тээврийн салбарт олгосон зээлийн үлдэгдэл, 18.2% буюу 27.7 тэрбум төгрөгийг тогтвортой хот төлөвлөлт ба барилгын салбарт олгосон зээлийн үлдэгдэл, 21.0% буюу 32.1 тэрбум төгрөгийг эрчим хүчний үр ашиг салбарт олгосон зээлийн үлдэгдэл, 6.4% буюу 9.8 тэрбум төгрөгийг тогтвортой хөдөө аж, ахуй салбарт олгосон зээлийн үлдэгдэл, 7.7% буюу 11.7 тэрбум төгрөгийг эрүүл мэнд ангиллын салбарт олгосон зээлийн үлдэгдэл, болон 16.4% буюу 25.1 тэрбум төгрөгийг бусад ангиллын салбарт олгосон зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар 2022 оны 03 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд зохион байгуулсан “Ногоон санхүүжилт – Бүс нутгийн чуулган”-аар уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлыг бууруулах чиглэлээр бүс нутгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, тогтвортой, ногоон санхүүжилтийг хөгжүүлэх, “Ногоон хөгжлийн сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх талаар

хэлэлцэн, зөвлөмж гаргасан. Зөвлөмжийн 1 дүгээр бүлгийн 1.3-т “Ногоон зээлийг банкны салбарт 10 хувь, ББСБ-уудад 5 хувьд хүргэхэд шаардлагатай бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх, ногоон зээлд эрсдэлийн сан байгуулах, хөнгөлөлт урамшуулал олгох, ногоон зээлийн эх үүсвэрийн свопын зардлыг бууруулах зэрэг хөшүүрэг бий болгох” үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хүлээсэн. Үүний дагуу 2022 оны 1 дүгээр улирлаас эхлэн “Монгол Улсын Ногоон таксономи”-ийн үндсэн ангиллын дагуу ББСБ-уудаас “Ногоон зээлийн тайлан”-г авч эхэлсэн. 2022 оны жилийн эцсийн байдлаар 117.4 сая төгрөгийн ногоон зээлийн үлдэгдэлтэй байсан бол, 2025 оны мөн улиралд ногоон зээлийн үлдэгдэл 1.3 дахин өсч 152.7 тэрбум төгрөгийн ногоон зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Зураг 8 Сүүлийн 3 жилийн байдлаар ногоон зээлийн үлдэгдэл(тэрбум төгрөгөөр)



Нийт зээлийн үлдэгдлийн 87.5% буюу 133.7 тэрбум төгрөг нь хэвийн, 5.9% буюу 9.0 тэрбум төгрөг нь анхаарал хандуулах, 6.6% буюу 10.0 тэрбум төгрөг нь чанаргүй ангилалд ангилагдсан байна.

Зураг 9 Ногоон зээлийн багцын чанар (ногоон таксономийн 12 ангиллаар)



Факторингийн тооцооны авлага

Факторингийн тооцооны авлага өмнөх оны мөн үеэс 88.2 хувиар буюу 50.3 тэрбум төгрөгөөр өсөж, 27 ББСБ 107.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ. 2025 оны жилийн эцсийн байдлаар 1.2 тэрбум төгрөгийн факторингийн тооцооны хүүгийн авлага хуримтлуулан бүртгэсэн байна. Нийт 20.0 тэрбум төгрөгийн анхаарал хандуулах болон чанаргүй факторингийн үлдэгдэлд 7.9 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 99.6 тэрбум төгрөгийн цэвэр үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 20 Факторингийн тооцооны авлагын ангилал (сая төгрөгөөр)

Нийт факторингийн тооцооны авлага	2024		2025		Өөрчлөлт	
	Нийт дүн	Эзлэх хувь	Нийт дүн	Нийт дүн	Эзлэх хувь	
	57,101.3	100.0%	107,449.1	100.0%	50,347.8	88.2%
Хэвийн	49,029.2	85.9%	86,217.8	80.2%	37,188.6	75.8%
Анхаарал хандуулах	1,983.9	3.5%	5,720.7	5.3%	3,736.8	188.4%
Чанаргүй	5,263.5	9.2%	14,290.5	13.3%	9,027.0	171.5%
Хэвийн бус	1,548.2	2.7%	5,357.9	5.0%	3,809.7	246.1%
Эргэлзээтэй	1,725.5	3.0%	5,356.3	5.0%	3,630.8	210.4%
Муу	1,989.8	3.5%	3,576.3	3.3%	1,586.5	79.7%
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	2,819.5	4.9%	7,880.0	7.3%	5,060.4	179.5%
Факторингийн тооцооны хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	824.8	1.4%	1,220.1	1.1%	395.4	47.9%

Факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад өссөн ба факторингийн тусгай зөвшөөрөлтэй 60 ББСБ-уудаас 32 ББСБ нь тайлант хугацаанд факторингийн үйл ажиллагаа эрхэлсэн байна.

Үүсмэл санхүүгийн хөрөнгө, бусад санхүүгийн хөрөнгө

2025 оны жилийн эцсийн байдлаар 5 ББСБ 6.1 тэрбум төгрөгийн своп арилжаа хийсэн байна. Бусад санхүүгийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 64.7 хувь буюу 101.0 тэрбум төгрөгөөр өсөж 257.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 21 Бусад хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл-тэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Үүсмэл санхүүгийн хөрөнгө	15,818.1	6,118.1	11,941.2	3,876.9	-	15,818.1	-	327.7	98.1
Своп арилжаа	6,118.1	6,118.1	2,241.2	3,876.9	-	6,118.1	-	327.7	98.1
Бусад санхүүгийн хөрөнгө	9,700.0	-	9,700.0	-	-	9,700.0	-	-	-
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны авлага	257,060.9	176,233.1	72,083.0	184,977.9	0.0	253,166.2	3,894.7	36,979.6	11,050.1
Авлага(цэвэр дүнгээр)	25,818.2	25,818.2	-	25,818.2	-	25,818.2	-	-	-
Салбар хоорондын тооцоо	194,416.2	125,636.7	62,018.9	132,397.3	0.0	190,889.3	3,526.9	36,972.5	10,955.2
Өмчлөх бусад хөрөнгө – санхүүгийн хөрөнгө (цэвэр дүнгээр)	5,121.7	4,744.2	274.6	4,847.1	-	4,869.9	251.8	-	-
Бусад	4,743.4	172.7	4,682.8	60.6	-	4,743.4	-	-	94.9

Санхүүгийн бус хөрөнгө

ББСБ-ууд 2025 оны жилийн байдлаар 242.9 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлд 67.4 тэрбум төгрөгийн элэгдэл байгуулж, 38.0 сая төгрөгийн үнэ цэнийн бууралтыг бүртгэсэн байгаа бол 105.0 тэрбум төгрөгийн биет бус хөрөнгийн үлдэгдэлд 38.4 тэрбум төгрөгийн хорогдол байгуулсан байна.

Ингэснээр тайлант хугацаанд 175.4 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө, 66.6 тэрбум төгрөгийн биет бус хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 22 Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, түрээсийн хөрөнгө, биет бус хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр)

Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, түрээсийн хөрөнгө, биет бус хөрөнгө	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Үндсэн хөрөнгө (цэврээр)	175,401.5	116,086.3	61,927.5	113,474.1	445.6	171,987.0	3,414.5	11,759.7	13,361.0
Барилга, байгууламж	88,987.0	64,112.1	24,218.2	64,768.9	81.1	87,497.7	1,489.3	5,201.8	7,562.2
Компьютер, дагалдах хэрэгсэл	12,322.7	8,925.1	4,378.1	7,944.6	23.8	11,876.5	446.2	1,339.0	1,121.6
Тээврийн хэрэгсэл	44,372.8	20,752.9	25,592.5	18,780.3	274.9	43,339.8	1,033.0	1,253.9	1,741.4
Тавилга, эд хогшил	19,711.4	13,513.5	6,955.8	12,755.6	59.3	19,278.9	432.5	1,867.2	1,997.0
Түрээсийн хөрөнгө	3,727.4	3,669.7	114.9	3,612.5	-	3,718.5	8.9	273.4	-
Борлуулаад буцаан түрээсэлсэн хөрөнгө	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад үндсэн хөрөнгө	6,280.2	5,112.9	668.0	5,612.2	6.6	6,275.6	4.6	1,824.3	938.8
Биет бус хөрөнгө (цэврээр)	66,628.9	47,151.2	10,664.9	55,964.0	3.7	66,427.7	201.2	10,814.5	4,404.8
Зохиогчийн эрх	27.1	-	27.1	-	-	7.9	19.2	-	-
Програм хайгамж	41,965.0	29,028.3	3,129.8	38,835.2	3.7	41,808.6	156.4	5,137.5	2,644.5
Мэдээллийн сан	12.0	12.0	-	12.0	-	12.0	-	12.0	-
Патент	8.0	1.5	8.0	-	-	8.0	-	-	-
Барааны тэмдэг	42.7	18.2	-	42.7	-	42.7	-	-	-
Тусгай зөвшөөрөл	18.8	-	-	18.8	-	18.8	-	-	-
Газар эзэмших эрх	1,477.2	1,341.0	136.2	1,341.0	-	1,466.0	11.2	-	-
Ашиглах эрхтэй хөрөнгө	15,577.8	13,973.6	2,600.2	12,977.6	-	15,565.8	12.0	4,258.6	1,758.0
Бусад биет бус хөрөнгө	7,500.4	2,776.8	4,763.5	2,736.8	-	7,498.0	2.4	1,406.4	2.2

Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт

Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 27.4 хувиар буюу 1.9 их наяд төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 34.1 хувийг өр төлбөрийн өсөлт, 65.9 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Пассивын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 23 Пассивын үзүүлэлтүүд (сая төгрөгөөр)


Пассивын үзүүлэлтүүд	2024-III	Нийт дүнд	2025-III	Нийт дүнд	Өөрчлөлт	
	дүн	эзлэх хувь	дүн	эзлэх хувь	дүн	хувь
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	3,038,317.5	47.3%	3,921,608.4	46.0%	883,290.9	29.1%
САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	2,866,470.3	44.7%	3,692,896.9	43.3%	826,426.6	28.8%
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	1,062,760.9	16.6%	1,293,271.6	15.2%	230,510.7	21.7%
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	1,026,257.7	16.0%	1,445,010.0	16.9%	418,752.3	40.8%
Бусад эх үүсвэр	543,000.4	8.5%	709,866.7	8.3%	166,866.3	30.7%
Үүсмэл санхүүгийн өр төлбөр	1,151.6	0.0%	3,753.1	0.0%	2,601.4	225.9%
Бусад санхүүгийн өр төлбөр	232,876.9	3.6%	219,603.4	2.6%	-13,273.5	-5.7%
Хоёрдогч өглөг	422.9	0.0%	21,392.2	0.3%	20,969.3	4958.7%
Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	-	-	-	-	-
САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	171,847.2	2.7%	228,711.5	2.7%	56,864.3	33.1%
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,379,280.8	52.7%	4,607,724.7	54.0%	1,228,443.9	36.4%
Хувь нийлүүлсэн хөрөнгө	1,714,924.3	26.7%	2,110,670.8	24.7%	395,746.4	23.1%
Нэмж төлөгдсөн капитал	85,716.8	1.3%	106,105.8	1.2%	20,388.9	23.8%
Халаасны хувьцаа	-2,580.2	0.0%	2,580.2	0.0%	5,160.4	-200.0%
Үндсэн хөрөнгө, биет бус ХДҮН	5,243.6	0.1%	22,510.7	0.3%	17,267.1	329.3%
Хуримтлагдсан ашиг, алдагдал	1,501,679.6	23.4%	2,254,310.6	26.4%	752,631.0	50.1%
Бусад өмч	74,296.7	1.2%	116,707.2	1.4%	42,410.5	57.1%
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,417,598.3	100.0%	8,529,333.1	100%	2,111,734.8	32.9%
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,127,275.01	100%	9,076,736.2	100%	1,949,461.1	27.4%

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өр төлбөрөөс итгэлцлийн үйлчилгээний өглөг 1.2 дахин, банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 1.1 дахин, бусад эх үүсвэр 1.2

дахин, үүсмэл санхүүгийн өр төлбөр 10.6 дахин, бусад санхүүгийн өр төлбөр 0.9 дахин, барагдуулах ёстой хоёрдогч өглөгийн өр төлбөр 63.0 дахин өссөн бол өөрийн хөрөнгөөс хуримтлагдсан ашиг 43.7 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгө 24.7 хувиар, нэмж төлөгдсөн капитал 23.0 хувиар тус тус өссөн байна.


Салбарын сүүлийн 5 жилийн байдлаарх санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг банкны салбартай харьцуулбал 2020 оны жилийн эцсийн байдлаар өөрийн хөрөнгө банкны салбарын 47.4 хувьд хүрдэг байсан бол 2025 оны жилийн эцсийн байдлаар 62.0 хувьд хүрч байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар 575 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ арилжааны банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн 123.2 хувьтай тэнцэж байна. Хуримтлагдсан ашгийн хувьд өмнөх оны мөн үед 40.8 хувьтай тэнцдэг байсан бол 2025 оны жилийн эцсийн байдлаар 7.6 пунктээр өсөж 48.4 хувьтай тэнцэж байна.

Зураг 10 Банкны салбарт эзлэх хувь (өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг)



Сүүлийн 5 жилийн пассивын үзүүлэлтийг харвал 2025 оны жилийн эцсийн байдлаар салбарын нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 2020 онтой харьцуулахад 3.4 дахин өсөж 5.0 их наяд төгрөгт, өр төлбөрийн хувьд 7.4 дахин өсөж 4.1 их наяд төгрөгт хүрсэн байна.


Зураг 11 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Итгэлцлийн үйлчилгээний өглөг

2025 оны жилийн эцсийн байдлаар итгэлцлийн үйлчилгээний өглөг өмнөх оны мөн үеэс 1.2 дахин буюу 249.5 тэрбум төгрөгөөр өсөж, итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 91 ББСБ-аас 89 ББСБ итгэлцэл татан төвлөрүүлсэн ба үүнээс тусгай зөвшөөрөлгүй 2 ББСБ байгаа ба тухайн ББСБ-уудын итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл өмнөх улиралд хүчингүй болсон байна. 15,588 итгэмжлэгчээс 1,438.6 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлсэн байна.

Зураг 12 Итгэлцлийн үйлчилгээний өглөг (тэрбум төгрөгөөр)



Нийт татан төвлөрүүлсэн итгэлцлийн өглөгийн 65.4 хувийг иргэдээс, 29.4 хувийг хувийн байгууллагаас, 0.4 хувийг эдийн засгийн харьяат бус этгээдээс татан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацаанд 1,368.2 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж үүнд 70.8 тэрбум төгрөгийн үр шим хуримтлуулан тооцож бүртгэсэн байна.

Хүснэгт 24 Итгэлцлийн үйлчилгээ (сая төгрөгөөр)

	Дүн	Хувь	Итгэл-цэлтэй	Уламж-лалт	Финтек	УБ	ХОН	ХК	ГХО
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	1,438,573.2	100%	1,437,269.1	158,347.3	1,280,225.9	1,432,911.3	5,661.9	272,079.3	158,929.5
Хувийн байгууллага	422,385.0	29.4%	422,385.0	45,475.5	376,909.5	417,802.2	4,582.9	116,675.7	50,096.1
Иргэд	940,368.4	65.4%	939,077.1	105,220.5	835,147.9	939,556.7	811.6	140,953.0	93,190.8
Өрх гэр, иргэдэд үйлчлэгч ашгийн бус байгууллага (Улс төрийн нам, сүм хийд)	-	0.0%	-	-	-	-	-	-	-
Эдийн засгийн харьяат бус	5,413.0	0.4%	5,413.0	-	5,413.0	5,413.0	-	0.2	5,412.8
Итгэлцлээр татсан хөрөнгөнд хуримтлуулаж тооцсон үр шим	70,751.2	4.9%	70,738.5	7,651.3	63,100.0	70,483.9	267.4	14,794.8	10,229.8
Итгэлцлээр татсан хөрөнгийн хойшлогдсон төлбөр	344.5	0.0%	344.5	-	344.5	344.5	-	344.5	-
Нийт итгэмжлэгчдийн тоо	15,588		15,584	795	14,793	15,531	57	6,683	406

Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр

2025 оны жилийн эцсийн байдлаар дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.1 дахин өсөж, 111 ББСБ дотоод, гадаадын банк болон санхүүгийн байгууллагаас 1,402.4 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 25 Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл- тэй	Уламж- лалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	1,402,371.9	1,245,100.8	262,163.5	1,140,208.4	438.5	1,400,647.1	1,724.8	529,303.2	383,124.9
Авсан зээл	1,365,842.6	1,215,655.0	254,049.6	1,111,793.0	438.5	1,364,120.7	1,721.8	513,941.1	374,440.8
Дотоодын	383,500.2	348,229.9	44,733.9	338,766.4	238.5	381,978.4	1,521.8	147,198.1	139,277.0
Гадаадын	679,331.1	676,190.8	145,164.6	534,166.6	-	679,331.1	-	333,732.6	235,163.7
Бусад	303,240.3	191,463.5	64,151.2	239,089.1	200.0	303,040.3	200.0	33,010.3	-
Бодит үнэ цэнийн залруулга	229.1	229.1	-	229.1	-	229.1	-	-	-
Хугацаа хэтрэлт	2,333.4	1,500.0	1,500.0	833.4	-	2,333.4	-	-	-
Дотоодын	2,051.9	1,500.0	1,500.0	551.9	-	2,051.9	-	-	-
Гадаадын	281.6	-	-	281.6	-	281.6	-	-	-
Бусад	-	-	-	-	-	-	-	-	-
Бодит үнэ цэнийн залруулга	2,834.9	2,834.9	-	2,834.9	-	2,834.9	-	1,870.5	1,835.6
Дотоодын	26.7	26.7	-	26.7	-	26.7	-	26.7	-
Гадаадын	2,800.0	2,800.0	-	2,800.0	-	2,800.0	-	1,835.6	1,835.6
Бусад	8.3	8.3	-	8.3	-	8.3	-	8.3	-
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	37,030.8	30,780.7	6,613.9	30,416.9	-	37,027.9	3.0	17,232.7	10,519.8
Дотоодын	5,809.7	5,693.1	3,332.6	2,477.2	-	5,806.8	3.0	499.3	515.6
Гадаадын	18,041.4	18,041.4	2,936.5	15,105.0	-	18,041.4	-	11,742.2	10,004.1
Бусад	13,179.7	7,046.2	344.9	12,834.8	-	13,179.7	-	4,991.1	-

Бусад эх үүсвэр

2025 оны жилийн эцсийн байдлаар 76 ББСБ 723.1 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй гарчээ. Үүнээс давхардсан тоогоор 66 ББСБ 645.0 тэрбум төгрөгийн өрийн бичиг, 2 ББСБ 41.1 тэрбум төгрөгийн үнэт цаас, 3 ББСБ төслийн зээл, 18 ББСБ 13.0 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэр, 5 ББСБ 1.4 их наяд төгрөгийн хойшлогдсон төлбөр, 64 ББСБ 25.1 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 26 Бусад эх үүсвэрийн бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл- тэй	Уламж- лалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Бусад эх үүсвэр	723,052.1	657,075.2	84,878.0	638,174.1	-	722,957.1	95.1	105,510.7	54,591.4
Гаргасан өрийн бичиг	644,997.6	582,337.6	79,472.0	565,525.6	-	644,997.6	-	99,335.1	50,000.0
Гаргасан үнэт цаас	41,130.6	41,130.6	1,600.0	39,530.6	-	41,130.6	-	-	1,600.0
Төслийн зээлийн санхүүжилт	210.9	36.8	35.8	175.1	-	210.9	-	-	-
Бусад	13,000.9	12,734.9	1,286.5	11,714.4	-	12,910.9	90.0	4,825.7	2,063.9
Бусад эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	1,355.6	1,196.5	301.9	1,053.7	-	1,355.6	-	515.8	386.6
Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	25,067.7	22,031.7	2,785.7	22,282.1	-	25,062.7	5.1	1,865.8	1,314.0

ББСБ-аас гаргасан өрийн бичиг


ББСБ-ууд өрийн бичиг гаргахдаа “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах үүрэгтэй.

2025 оны жилийн эцсийн байдлаар биржийн бус зах зээл дээр 66 ББСБ 617.1 сая төгрөг татан төвлөрүүлсэн тухай тоо мэдээ ирүүлсэн байна.

Биржийн зах зээл дээр 2025 оны жилийн эцсийн байдлаар 3 ББСБ 33.5 тэрбум төгрөгийг бондыг татан төвлөрүүлсэн байна.

66 ББСБ нээлттэй болон хаалттай хүрээнд 645.0 тэрбум төгрөгийн өрийн бичгийн үлдэгдэлтэй гарсан байгаа нь 2020 оны мөн үеэс 10.3 дахин өссөн үзүүлэлт юм.


Зураг 13 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Төслийн зээлийн санхүүжилт

Төсөл хөтөлбөрөөс 3 ББСБ 210.9 сая төгрөгийг татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна. Төслийн зээлийн санхүүжилт 2020 оны мөн үеэс 18.7 тэрбум төгрөг буюу 9.8 дахин, өмнөх оны мөн үеэс 13.4 тэрбум төгрөг буюу 7.4 дахин буурсан байна.

Зураг 14 Төслийн зээлийн санхүүжилт сүүлийн 5 жилийн байдлаар



Төслийн зээлийн санхүүжилтийг олгосон субъектээр нь ангилж харвал 36.6 хувь нь гадаадын төслийн, 63.4 хувь нь дотоодын санхүүжилттэй төслийн санхүүжилтийн зээл бүрдүүлж байна.

Хүснэгт 27 Төслийн зээл санхүүжилт (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл-тэй	Уламж-лалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Төслийн зээлийн санхүүжилт	210.9	36.8	35.8	175.1	-	210.9	-	-	-
Засгийн газрын санхүүжилттэй	-	-	-	-	-	-	-	-	-
Гадаадын санхүүжилттэй	77.1	-	-	77.1	-	77.1	-	-	-
Дотоодын санхүүжилттэй	133.7	36.8	35.8	98.0	-	133.7	-	-	-
Жижиг дунд үйлдвэрлэлийн төслийн санхүүжилтийн зээл	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад	-	-	-	-	-	-	-	-	-
Зах зээлийн хүүгийн түвшнээс өндөр буюу бага хүү бүхий зээлийн бодит үнэ цэнийн тохируулга	-	-	-	-	-	-	-	-	-

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ)

2025 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-уудын гаргасан ХБҮЦ-ыг харвал 18-24 сарын хугацаатай, жилийн 17.0-20.0 хувийн хүүтэй, 6.0-50.0 тэрбум төгрөгийн буюу нийт 288 тэрбум төгрөгийн 8 ББСБ-ийн нээлттэй зах зээлд гаргасан ХБҮЦ байна.

Бусад санхүүгийн өр төлбөр

2025 оны жилийн эцсийн байдлаар 5 ББСБ 4.9 тэрбум төгрөгийн үүсмэл санхүүгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй, 94 ББСБ 218.9 тэрбум төгрөгийн бусад санхүүгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй, 8 ББСБ 80.9 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 28 Бусад өр төлбөр (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Үүсмэл санхүүгийн өр төлбөр	4,886.1	4,886.1	660.4	4,225.7	-	4,886.1	-	676.6	355.7
Форвард арилжаа	-	-	-	-	-	-	-	-	-
Своп арилжаа	4,688.5	4,688.5	462.7	4,225.7	-	4,688.5	-	676.6	355.7
Опшин арилжаа	-	-	-	-	-	-	-	-	-
Фьючерс арилжаа	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад арилжаа	197.6	197.6	197.6	-	-	197.6	-	-	-
Бусад санхүүгийн өр төлбөр	218,848.6	182,465.4	49,385.7	169,462.9	0.5	217,888.2	960.4	43,139.5	34,915.2
Хоёрдогч өглөг	80,865.6	435.6	296.9	80,568.7	-	80,665.6	200.0	19.2	-
Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	527.3	527.3	-	527.3	-	527.3	-	-	-

Санхүүгийн бус өр төлбөр

Санхүүгийн бус өр төлбөрийн 60.1 хувийг бусад өр төлбөр, 22.9 хувийг тайлант үеийн орлогын албан татварын өглөг, 11.9 хувийг бусад татварын өглөг, 0.6 хувийг урьдчилж орсон орлого, 2.3 хувийг цалингийн өглөг, 2.2 хувийг бусад өглөг бүрдүүлж байна.

Хүснэгт 29 Санхүүгийн бус өр төлбөр (сая төгрөгөөр)

САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	Дүн	Итгэлцэл-тэй	Уламж-лалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	252,249.6	156,640.6	89,770.4	162,479.2	205.3	250,025.9	2,223.7	26,501.4	11,880.9
Цалингийн өглөг	5,823.1	5,021.2	872.0	4,951.1	40.6	5,812.0	11.1	1,402.9	1,262.8
ЭМ, НДШ-ийн өглөг	1,205.9	407.7	723.3	482.7	25.3	1,181.4	24.5	36.7	88.0
Тайлант үеийн орлогын албан татварын өглөг	57,794.6	38,965.7	20,767.0	37,027.5	48.0	57,184.0	610.6	3,452.0	1,454.2
Бусад татварын өглөг	30,074.6	26,513.8	5,586.6	24,487.9	87.8	29,933.6	140.9	8,431.3	7,071.1
Хойшлогдсон татварын өглөг	2,375.2	1,835.4	610.0	1,765.2	0.4	2,184.7	190.5	444.5	112.0
Хойшлогдсон орлого	1,806.7	1,799.0	1,347.5	459.3	-	1,806.7	-	-	-
Урьдчилж орсон орлого	1,518.0	1,152.8	821.6	696.4	-	1,509.8	8.2	209.5	60.8
Борлуулах зорилгоор эзэмшиж буй өр төлбөр	2.1	-	2.1	-	-	2.1	-	-	-
Бусад	151,601.9	80,906.8	58,994.4	92,607.6	3.2	150,364.2	1,237.8	12,524.6	1,831.9
Нөөц, болзошгүй өр төлбөр	47.6	38.2	46.1	1.4	-	47.6	-	-	-

Өөрийн хөрөнгө

ББСБ-уудын өөрийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 35.0 хувиар буюу 1,284.1 тэрбум төгрөгөөр өсөж 5.0 их наяд төгрөгт хүрсэн нь нийт активын 54.6 хувийг бүрдүүлж байна. ББСБ-уудын өөрийн хөрөнгийн 45.1 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгө, 49.5 хувийг хуримтлагдсан ашиг, 5.4 хувийг өөрийн хөрөнгийн бусад хэсэг бүрдүүлж байна.

Хүснэгт 30 Өөрийн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр)

	Дүн	Итгэл-цэлтэй	Уламж-лалт	Фин-тек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Хувь нийлүүлсэн хөрөнгө	2,233.3	1,051.4	1,266.2	967.0	23.6	2,161.3	71.9	59.4	147.5
Нэмж төлөгдсөн капитал	107.7	106.9	18.9	88.8	0.0	107.7	0.1	68.4	48.8
Халаасны хувьцаа	2.6	2.6	0.2	2.4	-	2.6	-	2.4	0.0
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	23.1	15.5	0.3	22.8	-	23.0	0.1	-	0.0
Хуримтлагдсан ашиг, алдагдал	2,452.7	1,774.4	859.9	1,592.8	10.8	2,404.9	47.8	285.5	190.8
Бусад өмч	141.2	136.0	10.6	130.6	-	140.0	1.1	41.5	7.9
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,955.4	3,081.6	2,155.7	2,799.7	34.5	4,834.3	121.1	452.5	395.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,076.7	6,766.0	2,801.2	6,275.6	35.1	8,944.8	131.9	1,429.7	1,038.8
Нийт хөрөнгөд эзлэх хувь	0.5	0.5	0.8	0.4	1.0	0.5	0.9	0.3	0.4

Хувь нийлүүлсэн хөрөнгө


Хувь нийлүүлсэн хөрөнгө нь өмнөх оны мөн үеэс 24.7 хувь буюу 442.9 тэрбум төгрөгөөр өсөж 2.2 их наяд төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 31 Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Хувь нийлүүлсэн хөрөнгө	2,233,256.8	1,051,395.6	1,266,225.4	967,031.4	23,639.0	2,161,309.4	71,947.5	59,432.1	147,504.1
Давуу эрхийн хувьцаа (өөрийн хөрөнгө)	174,978.3	173,500.0	1,478.3	173,500.0	-	174,936.0	42.3	12,000.0	12,121.0
Энгийн хувьцаа - Хаалттай	2,010,846.5	830,463.5	1,258,710.7	752,135.8	23,639.0	1,938,941.3	71,905.2	-	112,152.7
Энгийн хувьцаа - Нээлттэй	47,432.1	47,432.1	6,036.4	41,395.7	-	47,432.1	-	47,432.1	23,230.4
Хоёрдогч өглөг (өөрийн хөрөнгө)	94,873.4	91,763.4	3,010.0	91,863.4	-	94,873.4	-	30,658.4	-
Хөрвөх өр төлбөр (өөрийн хөрөнгө)	-	-	-	-	-	-	-	-	-
Нэмж төлөгдсөн капитал	107,729.7	106,898.9	18,885.5	88,844.2	20.8	107,655.5	74.3	68,422.4	48,772.1
Давуу эрхийн хувьцаа	65.3	-	65.3	-	-	64.0	1.3	-	-
Энгийн хувьцаа	107,664.5	106,898.9	18,820.2	88,844.2	20.8	107,591.4	73.0	68,422.4	48,772.1
Халаасны хувьцаа	2,580.2	2,580.2	210.4	2,369.8	-	2,580.2	-	2,373.3	3.6
Давуу эрхийн хувьцаа	-	-	-	-	-	-	-	-	-
Энгийн хувьцаа	2,580.2	2,580.2	210.4	2,369.8	-	2,580.2	-	2,373.3	3.6

2025 оны жилийн эцсийн байдлаар 575 ББСБ-ын 2.0 их наяд төгрөгийн энгийн хувьцаа, 9 ББСБ-ын 175.0 тэрбум төгрөгийн давуу эрхийн хувьцаа, 4 ББСБ-ын 2.6 тэрбум төгрөгийн халаасны хувьцаа бүртгэгдсэн байна.

Зураг 15 Хувьцаат капитал сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын өөрийн хөрөнгийн хэмжээ 2.0 их наяд төгрөг байгаа нь нийт өөрийн хөрөнгийн 43.8 хувийг, бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн дүн 2.6 их наяд төгрөг байгаа нь нийт дүнгийн 78.3 хувийг бүрдүүлж байна. ББСБ-уудын үйл ажиллагаа өргөжиж, томрохын хэрээр бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлэх боломж нь нэмэгдэж байгаа тул эдгээр ББСБ-уудын зайны болон газар дээрх хяналт шалгалтыг сайжруулах шаардлагатай байна.

Хүснэгт 32 ХНХ-ийн интервал (тэрбум төгрөгөөр)

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	1,249.4	102	55.9%	17.7%	7.3	1	6.9	1	-	-
2.5-5.0 тэрбум	913.1	324	40.9%	56.3%	5.8	2	5.0	2	-	-
1.9-2.5 тэрбум	4.3	2	0.2%	0.3%	-	-	2.4	1	1.9	1
1.4-1.9 тэрбум	10.6	7	0.5%	1.2%	3.2	2	6.1	4	1.4	1
0.6-1.4 тэрбум	22.7	26	1.0%	4.5%	10.8	13	8.0	9	2.9	3
0.6 тэрбум хүртэлх	33.1	114	1.5%	19.8%	0.0	0	16.6	63	17.5	55
НИЙТ	2,233.3	575	100.0%	100.0%	27.0	18	45.0	80	23.6	60

2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 426 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 96.8% буюу 2.2 их наяд төгрөг байна. Харин 2.5 тэрбум төгрөг хүртэлх хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 149 ББСБ-ын 70.7 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 3.2 хувийг бүрдүүлж байна.

Өөрийн хөрөнгийн бусад хэсэг

2025 оны жилийн эцсийн байдлаар 35 ББСБ 23.1 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, 109 ББСБ 141.2 тэрбум төгрөгийн бусад өмчийн үлдэгдэлтэй гарчээ.


Хүснэгт 33 Бусад өмч, сангуудын бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	23,100.9	15,517.2	321.0	22,779.9	-	22,961.0	139.9	-	6.5
Бусад өмч	141,164.4	135,980.9	10,570.7	130,593.7	-	140,031.2	1,133.2	41,466.9	7,914.2

Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг өмнөх оны мөн үеэс 43.7% буюу 746.4 тэрбум төгрөгөөр өсөж 2.5 их наяд төгрөгт хүрчээ.


Зураг 16 Хуримтлагдсан ашиг/алдагдал (тэрбум төгрөгөөр)



Тайлант хугацаанд 508 ББСБ нийт 952.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бол 9 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй, 58 ББСБ 6.5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Алдагдалтай ажилласан 58 ББСБ дотор эх үүсвэр татан төвлөрүүлсэн 5 ББСБ байна. Эдгээрийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг яаралтай хийж гүйцэтгэх шаардлагатай.


Зураг 17 Тайлант үеийн ашиг/алдагдал (тэрбум төгрөгөөр)



Ашигт ажиллагаа

2025 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-ууд 2,718.0 тэрбум төгрөгийн орлого олж, 1,771.9 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 946.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Зураг 18 Ашигт ажиллагааны үзүүлэлт (тэрбум төгрөгөөр)



Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 48.7% буюу 889.8 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 56.8% буюу 641.6 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 35.6% буюу 248.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 34 Орлого, үр дүнгийн тайлан (харьцуулсан, сая төгрөгөөр)

Орлого, зардлын зүйл	2024	2025	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
НИЙТ ОРЛОГО	1,828,177.3	2,717,976.2	100.0%	889,798.9	48.7%
Хүүгийн орлого	1,644,097.6	2,390,609.8	88.0%	746,512.2	45.4%
Хүүгийн бус орлого	154,484.3	273,941.4	10.1%	119,457.1	77.3%
Бусад орлого, олз	29,595.4	52,456.7	1.9%	22,861.3	77.2%
Бусад дэлгэрэнгүй орлого	-	968.3	0.0%	968.3	0.0%
НИЙТ ЗАРДАЛ	1,130,301.1	1,771,906.0	100.0%	641,604.9	56.8%
Хүүгийн зардал	398,818.0	636,209.7	35.9%	237,391.7	59.5%
Хүүгийн бус зардал	458,970.6	612,378.3	34.6%	153,407.7	33.4%
Эрдэлийн сангийн зардал	114,526.2	296,196.9	16.7%	181,670.7	158.6%
Бусад зардал, гарз	20,659.7	30,166.5	1.7%	9,506.7	46.0%
Орлогын албан татварын зардал	137,326.6	196,954.8	11.1%	59,628.1	43.4%
ЦЭВЭР АШИГ	697,876.2	946,070.2		248,194.0	35.6%

Нийт орлогын 88.0 хувийг хүүгийн орлого, нийт зардлын 35.9 хувийг хүүгийн зардал, 34.6 хувийг хүүгийн бус зардал бүрдүүлж байна. Хүүгийн бус зардлын 85.7 хувийг үйл ажиллагааны бусад зардал бүрдүүлж байгаа бөгөөд үүний 47.4 хувийг ажилтнуудын цалинтай холбоотой зардал бүрдүүлж байна.

Хүснэгт 35 Орлого, үр дүнгийн тайлан (тэр төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
НИЙТ ОРЛОГО	2,718.0	2,129.5	682.1	2,035.9	5.6	2,681.8	36.2	444.7	274.0
Хүүгийн орлого	2,390.6	1,931.1	567.4	1,823.2	0.1	2,357.9	32.7	403.0	254.4
Хүүгийн бус орлого	273.9	154.0	98.4	175.6	5.5	270.9	3.0	24.8	6.9
Бусад орлого, олз	52.5	44.4	15.4	37.1	0.0	52.1	0.4	17.0	12.7
Бусад дэлгэрэнгүй орлого	1.0	(0.1)	0.9	0.0	-	0.8	0.1	-	(0.1)
НИЙТ ЗАРДАЛ	1,771.9	1,439.8	380.3	1,391.6	3.0	1,753.9	18.0	348.5	215.7
Хүүгийн зардал	636.2	583.6	93.2	543.0	0.0	634.3	1.9	163.8	107.0
Хүүгийн бус зардал	612.4	440.8	167.9	444.5	2.8	601.2	11.2	82.3	56.0
Арилжааны зардал	4.3	3.3	1.5	2.8	0.0	4.3	0.0	0.4	0.2
Хани, үнэлгээний тэгшитгэлийн зардал	40.7	37.5	7.5	33.2	0.1	40.7	0.0	7.0	0.3
Хураамж, шимтгэлийн зардал	42.4	39.3	4.5	37.9	0.4	42.2	0.1	16.7	12.7
Үйл ажиллагааны бусад зардал	525.0	360.7	154.4	370.6	2.3	513.9	11.1	58.2	42.9
Эрсдэлийн сангийн зардал	296.2	232.9	65.9	230.3	-	293.2	3.0	76.2	38.3
Бусад зардал, гарз	30.2	21.2	10.3	19.9	0.1	29.6	0.5	3.8	3.1
ОАТ-ын зардал	197.0	161.2	43.1	153.8	0.1	195.5	1.4	22.4	11.2
НИЙТ ЦЭВЭР ОРЛОГО	946.1	689.7	301.8	644.3	2.6	927.9	18.2	96.2	58.2

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 575 ББСБ-ын 88.7% буюу 510 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 11.3 хувь нь буюу 65 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 60 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 4 ББСБ, 4 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ байна.

Хүснэгт 36 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд (үзүүлэлт бүрээр)

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	Итгэлцлэл /91 ББСБ/		Итгэлцлэл, ГВА-аас бусад /424 ББСБ/		ЗГВА /60 ББСБ/		Нийт /575 ББСБ/	
		√	X	√	X	√	X	√	X
1.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	91	-	424	-	60	-	424	-
2.	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	91	-	424	-	60	-	424	-
3.	Өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	91	-	424	-	60	-	424	-
4.	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	91	-	420	4	60	-	420	4
5.	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+илүү,- дутуу)	88	3	396	28	60	-	396	28
6.	Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	91	-	418	6			-	418
7.	ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	91	-	424	-			-	424
8.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа	91	-	422	2			-	422
9.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	91	-	419	5			-	419
10.	Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	91	-	424	-	XXX		-	424
11.	Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	91	-	423	1			-	423
12.	Монголын хөрөнгийн биржийн “Г”, “Ш” ангиллын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа	91	-	424	-			-	424
13.	Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	91	-	424	-			-	424
14.	Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа	91	-	424	-			-	424
15.	Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	91	-	419	5			-	419
16.	Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	91	-		XXX			91	-

17.	Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн нөөц сан	87	4	XXX	1			4	XXX
18.	Өрийн бичгийн зохистой харьцаа	87	4	421	3			4	421
19.	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	91	-	418	6	59	1	418	6


Тайлбар: √ - ЗХШҮ хангасан ББСБ-ын тоо, X - ЗХШҮ хангаагүй ББСБ-ын тоо

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс хөрөнгө (актив)-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ дутуу байгуулсан 31 ББСБ, нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа алдагдсан 6 ББСБ, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 5 ББСБ, өрийн бичгийн зохистой харьцаа алдагдсан 7 ББСБ, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 7 ББСБ байгаа нь хамгийн их алдагдсан харьцаа үзүүлэлтүүд байна.

Өгөөжийн үзүүлэлтүүд

2025 оны жилийн эцсийн байдлаар салбарын нийт хөрөнгийн өгөөж 11.7 хувь нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1 пунктээр буурч, харин өөрийн хөрөнгийн өгөөж 21.9 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1 пунктээр өссөн байна.

Зураг 19 Салбарын өгөөжийн үзүүлэлт сүүлийн 5 жилээр



Гадаад валютын арилжааны мэдээ

Тайлант хугацаанд буюу 2025 оны жилийн эцсийн байдлаар гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй 165 ББСБ-аас ирүүлсэн тайлан мэдээгээр 7.3 их наяд төгрөгийн валют худалдан авсан нь банкны салбарын 9.7 хувьтай, 7.5 их наяд төгрөгийн валют зарсан нь банкны салбарын 10.4 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 37 2025 оны III улирлын байдлаарх валют арилжааны мэдээ (сая төгрөгөөр)

	Нийт дүн		Авсан		Зарсан	
	Авсан	Зарсан	I-II улирал	I-II улирал	III-IV улирал	III-IV улирал
Нийт дүн	7,321,892.7	7,462,950.3	3,420,047.9	3,590,791.3	3,901,844.8	3,872,159.0
АНУ доллар	3,711,512.3	3,892,903.6	1,769,368.9	1,990,974.4	1,942,143.4	1,901,929.2
Евро	329,010.6	317,990.2	139,492.0	137,809.4	189,518.6	180,180.8
Японы иен	97,369.7	97,607.4	43,738.6	40,732.8	53,631.1	56,874.6
Швейцар франк	20,834.3	20,427.9	9,769.5	9,684.5	11,064.8	10,743.4
Шведийн крон	105.1	67.8	32.6	28.0	72.5	39.8
Английн фунт	2,831.1	2,729.2	830.4	878.7	2,000.7	1,850.5
Энэтхэгийн рупи	8.8	9.0	8.8	9.0	0.0	0.0
Хонгконг доллар	10,256.9	10,278.0	4,050.9	4,430.7	6,206.0	5,847.3
ОХУ-ын рубль	964,904.8	910,009.1	446,562.1	380,710.6	518,342.7	529,298.5
Казахстан тэнгэ	98.2	94.5	28.8	19.6	69.4	74.9
БНХАУ-ын юань	2,022,257.7	2,033,580.3	935,447.3	947,601.5	1,086,810.4	1,085,978.8
БНСУ-ын вон	148,968.5	151,754.1	66,168.7	65,722.7	82,799.8	86,031.4
Канадын доллар	744.1	773.6	268.9	271.3	475.2	502.3
Австралийн доллар	5,619.3	5,358.5	2,587.0	2,502.4	3,032.3	2,856.1
Чех крон	33.7	40.1	11.8	5.7	21.9	34.4
Тайван доллар	1.1	1.2	1.1	1.2	0.0	0.0
Тайланд бат	217.5	263.1	116.3	136.2	101.2	126.9
Сингапур доллар	7,054.5	19,057.8	1,504.4	9,272.6	5,550.1	9,785.2
Малайзын ринггит	1.7	0.0	1.7	0.0	0.0	0.0
БНАСАУ-ын вон	58.1	0.0	58.1	0.0	0.0	0.0
Индонезийн рупп	4.7	5.0	0.0	0.0	4.7	5.0

Дүгнэлт

2025 оны жилийн эцсийн байдлаар тайлан мэдээг ирүүлбэл зохих 575 ББСБ-аас 562 ББСБ жилийн тайлан мэдээ ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 7 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр, нэр бүхий 6 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа. 2025 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 41,762 хувьцаа эзэмшигчдийн 575 ББСБ, 591 салбар нэгж, 10 төлөөлөгчийн газар, 6,578 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 4.1 сая харилцагч, 3.2 сая зээлдэгчид/давхардаагүйгээр /752,736/ хүрч үйлчилж байна.

Актив, пассивын бүтэц

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 27.4 хувиар өсөж, банкны салбарын 10.6%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 123.2%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19.5 пунктээр өссөн дүн юм.

2025 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 27.4 хувиар буюу 1.9 их наяд төгрөгөөр өсөж 9.1 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 75.2 хувийг зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 65.9 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

ББСБ-ууд нь ихэвчлэн өөрийн хөрөнгөд тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэг онцлогтой байсан хэдий ч сүүлийн жилүүдэд бусдаас итгэлцэл, өрийн бичиг, дотоод, гадаадын банк санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөр хэлбэрээр мөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах замаар эх үүсвэр татах нь нэмэгдэж байгаа тул тэдгээр /159 ББСБ/ ББСБ-уудын тайлан мэдээнд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна.

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 25.9 хувь буюу 1.5 их наяд төгрөгөөр өсөж 2025 оны жилийн эцсийн байдлаар 7.5 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 422.5 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 7.1 их наяд төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Зээлийн багцын 87.2 хувийг буюу 6.3 их наяд төгрөгийг хэвийн зээл, 4.4 хувийг буюу 318.6 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 8.4 хувийг буюу 605.6 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь өмнөх оны мөн үеэс 3.6 пунктээр буурсан бол, чанаргүй зээлийн хувь 2.3, анхаарал хандуулах зээлийн хувь 1.3 пунктээр тус тус өссөн байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 924.2 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 45.7 хувьд буюу 422.5 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй 82 ББСБ 75 финтек зээлийн аппликэйшнээр дамжуулж цахим зээлийн үйлчилгээ үзүүлж байна.

2.3 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт зээлдэгчийн 90.1 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 31.7 хувийг бүрдүүлж байна. Зөвхөн аппликэйшнээр нэг зээлдэгчид дунджаар 804.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь уламжлалт зээлийн дунджаас 19.6 дахин бага байна.

Өмнөх оны мөн үеэс финтек зээлдэгчийн тоо 62.4 хувиар өсөн 2,840,399-г хүрч, зээлийн үлдэгдлийн хэмжээ 69.3% буюу 0.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд 43 ББСБ 27,621 зээлдэгчид 180.4 тэрбум төгрөгийн зээлийг дунджаар 3.4 хувийн хүүтэйгээр олгож, 44 ББСБ-ын 19,078 зээлдэгчээс 144.9 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2025 оны жилийн эцсийн байдлаар 47 ББСБ 15,129 зээлдэгчийн 152.7

тэрбум төгрөгийн ногоон зээлийн үлдэгдэлтэй гарчээ. Энэ нь салбарын нийт зээлийн үлдэгдлийн 2.1%-тай тэнцэж байна.

Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 27.4 хувиар буюу 1.9 их наяд төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 34.1 хувийг өр төлбөрийн өсөлт, 65.9 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өр төлбөрөөс итгэлцлийн үйлчилгээний өглөг 1.2 дахин, банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 1.1 дахин, бусад эх үүсвэр 1.2 дахин, үүсмэл санхүүгийн өр төлбөр 10.6 дахин, бусад санхүүгийн өр төлбөр 0.9 дахин, барагдуулах ёстой хоёрдогч өглөгийн өр төлбөр 63.0 дахин өссөн бол өөрийн хөрөнгөөс хуримтлагдсан ашиг 43.7 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгө 24.7 хувиар, нэмж төлөгдсөн капитал 23.0 хувиар тус тус өссөн байна.

Ашигт ажиллагаа

2025 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-ууд 2,718.0 тэрбум төгрөгийн орлого олж, 1,771.9 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 946.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 48.7% буюу 889.8 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 56.8% буюу 641.6 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 35.6% буюу 248.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 575 ББСБ-ын 88.7% буюу 510 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 11.3 хувь нь буюу 65 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 60 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 4 ББСБ, 4 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ байна.

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс хөрөнгө (актив)-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ дутуу байгуулсан 31 ББСБ, нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа алдагдсан 6 ББСБ, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 5 ББСБ, өрийн бичгийн зохистой харьцаа алдагдсан 7 ББСБ, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 7 ББСБ байгаа нь хамгийн их алдагдсан харьцаа үзүүлэлтүүд байна.